

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН
ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

2013 оны 10 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

**ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 334 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 334.4 ДЭХ ХЭСГИЙН
ЗАРИМ ЗААЛТ ҮНДСЭН ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ЗААЛТЫГ ЗӨРЧСӨН ЭСЭХ ТУХАЙ
МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 11.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат /илтгэгч/, Ц.Сарантуяа, Д.Сугар, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч, иргэн Ц.Мөнхбат, өмгөөлөгч Н.Ганхуяг нар оролцов. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндорж хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй болно.

Хуралдаанаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 334 дүгээр зүйлийн 334.4 дэх хэсэгт "Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах, ялаас чөлөөлөх тухай захирамжид давж заалдах гомдол гаргаж болохгүй бөгөөд харин прокурор эсэргүүцэл бичиж болно." гэсний "...давж заалдах гомдол гаргаж болохгүй..." гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй. ..." гэснийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны оршин суугч, иргэн Ц.Мөнхбат Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"Монгол Улсын Их Хурлаас 2007 оны 8 дугаар сарын 9-ний өдөр Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлан гаргасан байна. Энэ хуулиар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 334 дүгээр зүйлийн 334.4 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулж хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах, ялаас чөлөөлөх тухай шүүгчийн захирамжид давж заалдах гомдол гаргахгүй байхаар хуульчилжээ.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "...шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй..." гэснийг ноцтой зөрчсөн гэж үзэж байна.

Тухайлбал, хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдах хуулийн шаардлагыг хангасан ялтан холбогдох шүүх хуралдаанаас түүнийг "тэнсэн суллахгүй" гэсэн шүүгчийн захирамжийг үндэслэлгүй гэж үзсэн, мөн шүүхийн шатанд процессын журам зөрчсөн, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, шүүхийн шийдвэртэй бусад байдлаар санал нийлээгүй тохиолдолд Үндсэн хуулиар баталгаажуулсан эрхээ хангуулах, зөрчигдсэн эрхээ сэргээх зорилгоор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах боломжийг хаасан заалт болжээ.

Нөгөө талаар, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200-А тогтоолоор баталсан "Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын пакт"-ын 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт "Ямар нэгэн гэмт хэрэгт шийтгүүлж ял заагдсан хүн бүр ... хуулийн дагуу дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй ..." гэж заасан агуулгад нийцэхгүй байна.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 334 дүгээр зүйлийн 334.4 дэх хэсэгт "... давж заалдах гомдол гаргаж болохгүй ..." гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй" гэсэн заалттай харшилж байгаа тул уг асуудлыг хянан үзэж шийдвэрлэж өгнө үү." гэсэн байна.

Хоёр. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндорж 2013 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

"Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэн эрх, эрх чөлөөгөө шүүхээр хамгаалуулах эрхийг баталгаажуулсан байдаг бөгөөд энэ утгаараа шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хуульчилж өгсөн.

Монгол Улсын иргэн өөрт хамааралтай хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт давж заалдах эрхтэй бөгөөд энэхүү давж заалдсан боловч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь бүх шатны шүүхээр тогтоогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага гарцаагүй хүлээлгэх зарчим эрүүгийн эрх зүйд үйлчилдэг бөгөөд хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэдгийг тогтоох, түүнд зохих шийтгэлийг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй буюу эрүүгийн ял оногдуулахгүй байхад эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа чиглэгддэг билээ.

Шүүхээс хорих ял оногдуулсан ялтан нь ялаа эдлэх нь зайлшгүй бөгөөд цаашид ял эдлүүлэхээс бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөх, ял эс хэрэглэх асуудлыг зөвхөн хуульд заасан тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд /Эрүүгийн хуулийн 74, 76 дугаар зүйл/ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 334 дүгээр зүйлд заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг үндэслэн гаргасан прокурорын дүгнэлтийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын оршин байгаа газрын шүүхийн шүүгч захирамж гаргаж шийдвэрлэдэг бөгөөд энэ захирамжид гомдол гаргаж болохгүй харин прокурор эсэргүүцэл бичиж болдог.